



**ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН 2024 ОНЫ “ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ АЖИЛТНУУДЫН САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ САЙЖРУУЛАХ ТУХАЙ” 01 АЛБАН ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын газар

2024 он

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжилт
1.	Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд ойртуулах, түргэн шуурхай хүргэх үүднээс Нийгмийн даатгалын цахим үйлчилгээ /callpro chatbot вэб сайт/ сайжруулах, мэдээллийг тухай бүр өгч ажиллах;	Жилийн турш	<p>Иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг шуурхай хүргэх зорилгоор Callpro үйлчилгээ болон 70382700 дугаарын утсыг ажиллуулж мэдээлэл зөвлөгөө өгч ажиллаж байна. Дээрх 2 дугаарт 2024 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс 9 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар иргэд, ААН-ээс Callpro үйлчилгээний 75091000 дугаарт 596, 70382700 дугаарт 140 нийт 735 дуудлага /давхардсан тоогоор/ ирсэн байна. Үүнээс 664 дуудлагад шууд хариу өгч, 127 дуудлага алдсан боловч алдсан дуудлагад эргэн холбогдож, шаардлагатай мэдээ мэдээллийг хариуцсан байцаагчаар шийдвэрлүүлж хариуг хүргүүлэн ажилласан. Chatbot үйлчилгээг нэвтрүүлэх төсөвгүй тул энэ үйлчилгээг цахим үйлчилгээнд нэвтрүүлээгүй байна. Мөн huvsgul.ndaatgal.mn веб хуудсанд 8 дугаар сарын 26-наас 9 дүгээр сарын 12-ны өдрийн хооронд цаг үеийн мэдээ мэдээллийг 7 удаа, видео мэдээллийг 6 удаа оруулсан байна.</p> <p>“Хөвсгөл аймгийн нийгмийн даатгалын газар” фэйсбүүк пэйж хуудсаар 09 дүгээр сарын 06-нд өндөр насны тэтгэврийн талаар шууд Live хийж 43 лайк, 15 коммент, 3400 үзэлт хандалттай, 09 дүгээр сарын 11-нд сайн дурын даатгалын талаар шууд Live хийж 98 лайк, 55 коммент, 52 шэйр, нийт 12700 хүний үзэлт хандалтийг тус тус авсан байна.</p>

			
2.	<p>Ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах, орлогын төлөвлөгөөг биелүүлэх зорилго бүхий аян зохион байгуулах</p>	<p>Жилийн турш</p>	<p>Нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагыг барагдуулах ажлын хүрээнд Монгол улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/199 тоот тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам” дагуу шат дараалласан арга хэмжээг авч ажиллаж байна.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/64 тоот “Нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулах ажлыг эрчимжүүлэх тухай” тушаалын дагуу 2024 оны 05-р сарын 27-оос 2024 оны 12-р сарын 20-ны хооронд “Орлого хамралт, авлага барагдуулах” аяны төлөвлөгөө гарган ажилласны үр дүнд өмнөх оны шимтгэлийн авлага 296 аж ахуйн нэгж байгууллагын 1540609,9 мянган төгрөгийн авлагаас 178 аж ахуйн нэгж байгууллагын 544653,7 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан ба 42,8 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. Төсөвт байгууллагуудын цалин нэмэгдсэний улмаас нийгмийн даатгалын шимтгэлийн</p>

			<p>өрийн хэмжээ нэмэгдэж байна. ААНБ-уудын нийгмийн даатгалын шимтгэлийг барагдуулахын тулд уулзалтын тэмдэглэл хөтлөсөн 45, график байгуулсан 2, утсаар мэдэгдсэн 28, нийт 75 аж ахуйн нэгж байгууллагад дээрх арга хэмжээг авч ажиллалаа.</p> <p>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 3948302,5 мянган төгрөгийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 100.8 хувиар биелүүллээ.</p>
3.	<p>“Авилга, ашиг сонирхолын зөрчилөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж албан хаагчдыг хамруулж, иргэд даатгуулагчдад авлигыг үл тэвчих уриалга бүхий зурагт хуудас, постер цахимаар байршуулах түгээн дэлгэрүүлэх</p>	10 дугаар сард	<p>Иргэд, олон нийтийг Авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс Авлигатай тэмцэх газрын постер, мэдээ мэдээллийг НДГ-ын фэйсбүүк пэйж хуудас, <a href="http://huvsgul.ndaatgal.mn">huvsgul.ndaatgal.mn</a> вэб хуудсаар тухай бүр нийтлэн түгээж ажилласан.</p> 
4.	<p>Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, орлого зарлага, хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг <a href="http://shilen.gov.mn">shilen.gov.mn</a>, <a href="http://shilendans.gov.mn">shilendans.gov.mn</a> сайтад хуулиар</p>	Жилийн турш	<p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны “Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хуваарь батлах тухай” А/20 дугаар тушаалын гуравдугаар хавсралтад заасан жагсаалтын дагуу нээлттэй мэдээллийг цахим хуудсанд, дөрөвдүгээр хавсралтад заасан жагсаалтын дагуу нээлттэй</p>

тогтоосон хугацаанд бүрэн байршуулж, иргэд олон нийтэд нээлттэй мэдээлэх

мэдээллийг мэдээллийн самбарт байршуулах, хэрэгжүүлэх ажлын хүрээнд мэдээллүүдээ shilen.gov.mn вэб сайтад 5 төрлийн 87 үзүүлэлтээр 100 хувь байршуулсан shilendans.gov.mn сайтад сан болон үйл ажиллагаа, хүний нөөцийн холбогдолтой 124 төрлийн нээлттэй мэдээллийг тогтмол оруулж байна.



№	Бүлгийн нэр	Шалгуур үзүүлэлтийн оноо				Нийт оноо	Хувь
		МХБ	ХНБ	МБББ	ЭСТБ		
1	Чиг үүрэг, үйл ажиллагааны стратег, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	540	540	540	480	2,100/2,160	97.22%
2	Хүний нөөцийн талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	120	150	150	150	570/840	67.86%
3	Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал	0	120	120	120	360/1,440	25%
4	Уушгын байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байгаа ил тод, нээлттэй байдал	120	120	120	120	480/480	100%
5	Бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдал	90	100	100	100	390/480	81.25%

5. Байцаагч, мэргэжилтнүүдийн чиг үүргийн дагуу Нийгмийн даатгалын багц хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан журам, дүрэм зааврыг хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах

10,11 дүгээр сард

2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд шинээр нэвтэрсэн "SICOS" программын талаарх танилцуулга, заавар, тэтгэвэр, тэтгэмжийн мэдээллийг программд оруулах, бодох, хянах мөн санхүүгийн орлого, зарлагын гүйлгээ таниулах, тооцоо тулгах, аж ахуйн нэгж байгууллагын тайлан хүлээж авахад анхаарах асуудал, сайн дурын даатгалын гэрээ байгуулах, төлөлтийн талаар нэгдсэн

			<p>нэг ойлголтыг өгөх зорилгоор НДЕГазрын 1 удаагийн сургалтад давхардсан тоогоор 42 байцаагч хамрагдсан байна. Мөн тус газраас тэтгэвэр тэтгэмжийн хяналтын байцаагч Б.Мөнхдэлгэр, сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Б.Болорцэцэг, орлого шимтгэлийн өр хариуцсан байцаагч Б.Алтанцэцэг нар дотоодын сургалтыг зохион байгуулж, ажилчдыг идэвхжүүлэх хуулийн мэдлэг олгох 3 удаагийн сургалтанд давхардсан тоогоор 76 албан хаагч, ажилчид хамрагдсан байна.</p>
6.	<p>Ажил олгогч даатгуулагч, иргэдэд зориулсан нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах нээлттэй хаалганы өдөрлөг, аян зохион байгуулах</p>	Жилийн турш	<p>2023 онд шинэчлэн батлагдсан Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг сурталчилан таниулах, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 2024 оны 01-р сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөж буй Нийгмийн даатгалын багц хуулийн өөрчлөлтийг ААНБ-уудад төлөвлөгөөний дагуу танхимаар 3 удаагийн сургалтаар 54 даатгуулагчийг хамруулж, цаг тухай бүр нь сургалтын мэдээллийг page хуудсаар байршуулан ажиллаж байна.</li> <li>• “Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч хүүхдүүдийн нөхцөл байдлын судалгаа” хэлэлцүүлгийг 09 дүгээр сарын 09-нд зохион байгуулж, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтэс, аймгийн ХГБХХГ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Цагдаагийн газар, Мөрөн сумын Засаг дарга, ЗДТГ-ын холбогдох мэргэжилтэн, Мөрөн сумын багийн Засаг дарга нар, Хөвсгөл аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүх, ЕБС-ийн нийгмийн ажилтнуудын төлөөлөл оролцон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч хүүхдүүдийн тулгамдсан асуудлын талаар ярилцаж санал солилцсон. Энэ арга хэмжээний хүрээнд 1036 иргэний судалгааг хийсэн.</li> <li>• Нийгмийн даатгалд шинээр 9 ААНБ бүртгэж 21 албан журмын даатгуулагчийг хамруулсан.</li> </ul>

			<ul style="list-style-type: none"> <li>-Албан даалгаврын биелэлтийн хугацаанд шинээр сайн дурын даатгалд 23 иргэн хамруулсан.</li> </ul>  
8.	Ажил олгогч иргэдээс ирүүлж буй өргөдөл, гомдол, хүлээн авах сувгийг нэмэгдүүлэх, мэдээллийг албан ёсны цахим хаяг, олон нийтэд ил тод байршуулах ирүүлсэн өргөдөл хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэх, хариу өгч ажиллах	Жилийн турш	<p>Ажил олгогч, иргэд даатгуулагчдаас бичгээр болон callpro үйлчилгээгээр ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг бичиг хэргийн ажилтан 7 хоног бүрийн даваа гарагийн өглөөний сонсголоор танилцуулж шийдвэрлэх хугацаа дуусах дөхсөн, хүлээгдэж байгаа өргөдөл гомдлын мэдээг танилцуулж биелэлтийг ханган ажиллаж байна.</p> <p>Оны эхнээс нийт 229 өргөдөл бичгээр ирсэн байна. Үүнээс шийдвэрлэсэн 193, хуулийн хугацаанд хүлээгдэж байгаа 36 өргөдөл байна. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 84,2 хувьтай байна. Албан даалгаврын биелэлтийн хугацаанд буюу 2024 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс 9 дүгээр сарын 12-ны өдрийг хүртэл хугацаанд бичгээр нийт 17 өргөдөл ирсэнээс 5 өргөдөл шийдвэрлэгдэж, 12 өргөдөл хуулийн хугацаанд хүлээгдэж байна.</p>

9.	Ажилтнуудын ажлын цаг ашиглалт, бүтээмжийг сайжруулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, албан хаагчдыг идэвхжүүлэх арга хэмжээ санаачлан зохион байгуулах	9, 10 дугаар сард	Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын Ажлын цаг ашиглалт бүтээмж, хариуцлагыг сайжруулах тухай 2024 оны А/139 дүгээр тушаалын дагуу Хөдөлмөрийн дотоод журманд зааснаар чөлөө олгох, авах асуудлыг журмын дагуу шийдвэрлэн ажиллаж байна. Мөн ажилтнуудын ажлын цаг ашиглалтыг Төийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем erp.e-mongolia.mn –д тогтмол бүртгэж, бүх ажилтан, албан хаагчдын гар утсанд erp e-chat аппликэйшн суулган цаг бүртгэлийг хялбаршуулж, хяналт тавин ажиллаж байна. Тэдний ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн ажил зохион байгуулах, илүү үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна.
10.	Намар, өвлийн бэлтгэл ажлыг хийх	9 дүгээр сард	Сангийн болон цахилгааны аюулгүй байдал, хаалга цонхны дулаалга зэрэг өвлийн бэлтгэл ажлуудыг хангаж ажиллаж байна.

ТАЙЛАН ХЯНАСАН:

ЗАХИРГАА ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА.....П.МАЙНБАЯР

ТАЙЛАН НЭГТСЭН:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН  
СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН ..... Б.БОЛОРЦЭЦЭГ  
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН.....Б.БЯМБАДУЛАМ